



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/15/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2024 он	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 70512127 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512123 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

ДӨРВӨЛЖ ОНӨААТҮГ
ЗАХИРАЛ С.ТҮВШИНДЭЛГЭР ТАНАА

2024.03.15 № 227
танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 03 дугаар тогтоолын дагуу цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, бохир усны үйлчилгээний суурь хураамжийг шинэчлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн татварын орлого 232.0 сая төгрөгийг Сангийн яам Дөрвөлж ОНӨААТҮГ-т бүртгэлтэй урт хугацаат зээлийн төлбөрт суутган тооцсоныг нягтлан бодох бүртгэлд тусгажээ.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

МӨРИЙН ДУГААР	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	769,739,331.98	1,202,590,922.62
1.1.2	Дансны авлага	829,884,430.62	645,594,403.98
1.1.4	Бусад авлага	8,895,211.43	2,073,298.94
1.1.6	Бараа материал	263,720,561.10	311,697,278.90
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	356,139,971.24	4,470,709.34
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,228,379,506.37	2,166,426,613.78
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,795,340,938.39	11,376,528,372.56
1.2.2	Биет бус хөрөнгө	1,282,835,185.06	1,280,689,409.76
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,078,176,123.45	12,657,217,782.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,306,555,629.82	14,823,644,396.10
2.1.1.1	Дансны өглөг	17,293,325.03	22,562,601.60
2.1.1.3	Татварын өр	6,876,210.25	61,230,617.06
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	8,566,176.55	13,692,909.02
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	728,344.78	1,818,606.69
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	33,464,056.61	99,304,734.37
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,805,000,000.00	1,573,000,000.00
2.1.2.5	Хойшлогдсон орлого	3,063,072,957.70	3,614,602,598.55
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,868,072,957.70	5,187,602,598.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,901,537,014.31	5,286,907,332.92
2.3.1	Өмч: - төрийн	17,891,641,028.25	17,891,641,028.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	236,955,957.55	236,955,957.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(7,723,578,370.29)	(8,591,859,922.62)
2.3.9.1	Тайлант үеийн ашиг, алдагдал	(1,949,067,143.80)	(3,049,348,696.13)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг, алдагдал	(5,774,511,226.49)	(5,542,511,226.49)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	10,405,018,615.51	9,536,737,063.18
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,306,555,629.82	14,823,644,396.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
01	Борлуулалтын орлого /цэвэр/	7,208,031,576.70	7,442,411,816.51
02	Борлуулалтын өртөг	(7,591,746,697.94)	(8,848,113,013.94)
03	Нийт ашиг (алдагдал)	(383,715,121.24)	(1,405,701,197.43)
04	Түрээсийн орлого	46,946,727.16	25,954,545.25
05	Хүүний орлого	0.00	4,175,830.52
06	Ногдол ашгийн орлого		
07	Эрхийн шимтгэлийн орлого		
08	Бусад орлого	518,035,784.37	1,509,977,335.73
09	Борлуулалт, маркетингийн зардал	(351,096,169.62)	(451,895,414.71)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(442,230,689.36)	(514,490,161.42)
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	(3,254,605.39)	(134,955,941.83)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,090,909.09	(133,346,548.44)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(613,223,164.99)	(1,100,281,552.33)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(613,223,164.99)	(1,100,281,552.33)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(613,223,164.99)	(1,100,281,552.33)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(613,223,164.99)	(1,100,281,552.33)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(613,223,164.99)	(1,100,281,552.33)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлт	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	... оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
1	2024 оны 1-р сарын 01-ний үлдэгдэл	17,891,641,028.25					236,955,957.55	(7,723,578,370.29)	10,405,018,615.51
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	232,000,000.00	232,000,000.00
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(1,100,281,552.33)	(1,100,281,552.33)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00					0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт				0.00	0.00			0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00		
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00		0.00	0.00		0.00
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,891,641,028.25	0.00	0.00	0.00	0.00	236,955,957.55	(8,591,859,922.62)	9,536,737,063.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үе
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн(+)	8,736,372,784.50	9,650,723,834.06
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,099,585,895.91	7,838,511,598.54
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	1,392,588.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	720,505.00	5,082,326.00
	Бусад мөнгөн орлого	634,673,795.59	1,807,129,909.52
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(7,888,533,317.13)	(8,724,708,500.53)
	Ажиллагчдад төлсөн	(2,195,090,259.50)	(2,925,794,155.78)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(661,129,313.27)	(873,443,829.85)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(2,140,290,874.04)	(2,101,067,832.95)
	Ашиглалтын зардалд төлсөн	(677,220,611.38)	(951,053,730.00)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(745,128,590.55)	(591,202,964.72)
	Хүүний төлбөрт төлсөн	(4,533,912.64)	0.00
	Татварын байгууллагад төлсөн	(820,335,110.55)	(871,333,178.75)
	Даатгалын төлбөрт төлсөн	(31,485,350.00)	(1,601,385.00)
	Бусад мөнгөн зарлага	(613,319,295.20)	(409,211,423.48)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	847,839,467.37	926,015,333.53
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(135,904,216.08)	(493,163,742.89)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(135,904,216.08)	(493,163,742.89)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(135,904,216.08)	(493,163,742.89)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	711,935,251.29	432,851,590.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,804,080.69	769,739,331.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	769,739,331.98	1,202,590,922.62

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2022 оны Гүйцэтгэл	2023 он	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдхүүн үйлдвэрлэлт				
	Дулаан	мян.Гкал	75.20	73.31	75.90
	Цэвэр ус	мян.м3	236.10	266.13	243.69
	Бохир ус	мян.м3	195.63	226.31	206.82
2	Нийт орлого	мян.төг	7,775,105.00	9,392,138.00	8,982,519.50
	Дулаан борлуулалт	мян.төг		6,213,812.70	5,843,883.60
	Халуун ус борлуулалт	мян.төг		38,873.00	42,836.00
	Цэвэр ус борлуулалт	мян.төг		732,159.70	782,038.20
	Бохир ус борлуулалт	мян.төг	7,100,797.78	384,708.60	459,148.60
	- Улсын болон орон нутгийн төсвийн татаас	мян.төг	107,233.80	107,200.00	942,181.80
	-Төлбөрт үйлчилгээний орлого	мян.төг		47,344.00	47,871.40
	-түрээс	мян.төг		32,440.00	25,954.50
	-СӨХ-ийн орлого	мян.төг			130,951.40
	-Барааны борлуулалт	мян.төг			159,838.50
	-Хойшлогдсон орлого	мян.төг			318,761.10
	бусад гэх.мэт	мян.төг	567,073.42	1,835,600.00	229,054.40
	3	Нийт зардал	мян.төг	8,388,328.16	9,248,881.20
Цалин, ЭМНДШ-ийн зардал				3,521,497.80	3,778,944.08
Нүүрсний зардал				1,081,307.80	1,032,900.70
Шатахууны зардал				375,440.60	567,809.90
Цахилгааны зардал				838,744.40	809,015.30
Материалын зардал				1,130,466.00	1,068,047.33
Элэгдлийн зардал				2,055,980.10	1,779,897.10
Бусад зардал				245,444.50	1,046,186.60
Үүнээс: удирдлагын зардал		мян.төг	414,033.50	539,095.00	568,993.30
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(613,223.2)	143,256.8	(1,100,281.5)
5	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг			
6	Төсвийн төлбөр				
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.92	0.98	1.12
8	Нийт авлага	мян.төг	1,194,919.61	600,000.00	650,272.40
9	Нийт өглөг	мян.төг	4,901,537.00	-	98,893.13
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг		-	98,893.13
10	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	мян.төг		1,154,354.50	844,600.00
11	Ажиллагсадын тоо	мян.төг	281.00	235	214
12	Цалингийн сан	мян.төг	2518884.5	3,521,497.70	3,827,462.40
13	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	22,732,590.70		14,645,707.54
14	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	2,225,223.49		2,166,426.6
	үүнээс бараа материал	мян.төг	263,720.56		311,697.3
15	-үндсэн хөрөнгө	мян.төг	22468870.17		12,657,217.8

5 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх

5.1.2 Өр төлбөр авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх онуудад үүссэн авлага, өр төлбөр ихээр хуримтлагдсан.

Өгсөн зөвлөмж:

Өмнөх онуудад үүссэн авлага, өр төлбөрийг харилцагч байгууллагатай тулган баталгаажуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч, санхүүгийн тайлан бүртгэлд зарлуулаг хийх

5.1.3 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 171 мэдээллээс, хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, 16 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг мэдээлэлгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дотоод хяналттай холбоотой	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Өр төлбөр, авлагатай холбоотой	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
/мянган төгрөгөөр/										
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<i>Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй</i>	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-